

**БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

2017 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх ажил	Биелэлт
<b>Нэг. Сургалтын чиглэлээр</b>		
1.1.	Нийслэл дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын ажилтнуудын дунд архив, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийн дүрэм журмыг танилцуулах сургалт зохион байгуулах.	НЗД-ын А/252, А/177 дугаар захирамжуудын хэрэгжүүлэх талаар нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хорооны албан хаагчдад заавар зөвлөгөөг тогтмол өгч ажилласан. <b>Үүний хүрээнд:</b> Налайх дүүргийн Биеийн тамир спортын хороотой хамтран тус дүүргийн албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн биеийн тамир спортын хамтлагийн ахлагч, арга зүйчид, биеийн тамирын багш, хороодын нийгмийн ажилтнуудын дунд 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр албан хэрэг хөтлөлтийн eDoc програмын ашиглалт, хэрэглээний талаар арга зүй өгөх сургалтыг зохион байгуулсан. Сургалтад дүүргийн 45 байгууллагын 60 ажилтан, спорт хамтлагын ахлагч, арга зүйчид хамрагдсан.  Хэрэгжилт 100%
1.2.	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулж, мөрдөн ажиллах.	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг даргын <b>А/66</b> тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Тус дотоод журмыг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм, Хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг тодорхойлох тухай зөвлөмж, хөдөлмөрийн дотоод журам боловсруулах загвар, Ажлын цагийг нэгтгэн бодох журам, Ээлжийн амралтын олговор тооцох журам, Ээлжийн амралт олгох зааварыг үндэслэн боловсруулсан. Журам нь 12 бүлэг 109 зүйлтэй.  Хэрэгжилт 100%
1.3.	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.	Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг даргын <b>А/69</b> дугаар тушаалаар батлуулан ажилласан. Тус хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр тусгаж агуулгын хувьд 5 бүлэг 25 зүйлтэй батлагдсан.  Хэрэгжилт 90%

<p>1.4.</p>	<p>Нийслэлээс зохион байгуулж байгаа сургалтуудад холбогдох чиглэлээр мэргэжилтнүүдийг хамруулах.</p>	<p>Салбарын болон Нийслэлийн засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалтуудад чиглэл чиглэлийн дагуу албан хаагчдыг бүрэн хамруулсан. Жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>✦ Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/252 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан танхимын сургалтад 1 удаа, онлайн сургалтад 1 удаа хамрагдан өгсөн заавар, зөвлөмжийн дагуу Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодын албан хаагчдад “edoc.ub.gov.mn” програмын ашиглалтын талаар арга зүй өгч ажилласан.</li> <li>✦ Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодод тоон гарын үсгийн гэрчилгээ, е-токен төхөөрөмж авах ажлыг зохион байгуулж 10 байгууллагын хүсэлтийг Нийслэлийн мэдээлэл технологийн газарт хүргүүлж ажилласан. Тус арга хэмжээний хүрээнд Нийслэлийн мэдээлэл технологийн газар, Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан 2 удаагийн сургалтад хамрагдсан.</li> <li>✦ 2017 оны 05 дугаар сарын 31-нд НЗДТГ-н Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс зохион байгуулсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын сургалтад Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга А.Болдмаа, мэргэжилтэн Н.Өлзийжаргал, А.Намуун нар хамрагдсан.</li> <li>✦ Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Төрийн байгууллагуудын ажилтнуудад зориулсан гэр бүл, хүүхэд хамгааллын сургалтад мэргэжилтэн А.Намуун хамрагдсан.</li> <li>✦ БСШУСЯ-ны Биеийн тамир, спортын бодлогын газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Биеийн тамир, спортын газрын хамтарсан “Биеийн тамир, спортод хүн амын оролцоог эрчимжүүлэх нь” сургалтад 2017 оны 10 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга А.Болдмаа, мэргэжилтэн Н.Өлзийжаргал, Г.Бямбасайхан, А.Намуун нар хамрагдсан.</li> <li>✦ Биеийн тамир, спортын улсын анхдугаар тооллого явагдаж буйтай холбогдуулан Нийслэлийн хэмжээнд зохион байгуулах</li> </ul>
-------------	---	--

		<p>хяналтын байгууллагаар Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо, Нийслэлийн Статистикийн газрууд хамтран ажиллах юм. Тус ажилтай холбогдуулан 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр БСШУСЯ-ны хурлын танхимд, 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Статистикийн улсын хорооны сургалтын танхимд мэдээлэл хийж Спортын хөгжлийн хэлтсийн дарга С.Саранцэцэг, мэргэжилтэн Г.Бямбасайхан, А.Намуун нар хамрагдсан.</p> <p>✚ Удирдлагын академиас аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар, хороодын дарга нарт зориулан “Нийгмийн салбарын төрийн албан хаагчийн манлайлал” сэдэвт богино хугацааны сургалтыг 10 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулж байгууллагын дарга хамрагдсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
1.5.	<p>Хууль тогтоомжийн хэрэгжилт, мэдээлэл, мэдлэг олгох ажлын байрны сургалт зохион байгуулах.</p>	<p>Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хорооны дарга, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд “Хууль тогтоомж, эрх зүй”-н чиглэлээр сургалт, семинарыг Төрийн албаны ёс зүй, Зөрчлийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлт, Тоон гарын үсэг, Сэтгэл ханамжтай ажиллах сэтгэл зүй, Нийслэлийн Засаг даргын А/335 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэлийн нэгдсэн сан бүрдүүлэх журмыг хэрэгжүүлэх зэрэг сэдвийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хурлын "А" танхимд 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж 10 байгууллагын 40 гаруй албан хаагчид хамрагдсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
1.6.	<p>Мэргэжлээ дээшлүүлэх чиглэлээр их дээд сургуульд орой болон эчнээгээр суралцахад дэмжлэг үзүүлэх, сурах боломжоор хангах.</p>	<p>Тус хорооны мэргэжилтэн Б.Түвшинбаяр Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн бакалаврын эгчээ анги, мэргэжилтэн Б.Санчир Монгол Улсын Эрдмийн их сургуулийн Бизнесийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн бакалаврын оройн ангид суралцаж байгаа бөгөөд сурч боловсроход нь дэмжлэг үзүүлж ажлын ачааллыг хөнгөлөн, цагийн чөлөөг тогтмол олгож байна.</p>

		Хэрэгжилт 100%
1.7.	Дүүргийн БТС-ын байгууллагын удирдлагууд болон байгууллагын ажилтнуудын мэдээллийн цагийг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулах.	<p>Дүүргийн Биеийн тамир, спортын хороодын удирдлагуудын шуурхай зөвлөгөөн, мэдээллийн цагийг батлагдсан хуваарийн дагуу нийт 8 удаа зохион байгуулсан. Тус зөвлөгөөнөөр:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Төр захиргааны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар хийгдэж байгаа ажлууд,</li> <li>- Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан асуудлуудыг хэрэгжүүлэх ажлын явц,</li> <li>- Нийслэл, дүүргүүдийн БТС Хороодын үйл ажиллагааны талаарх мэдээлэл,</li> <li>- Нийслэл болон харьяа байгууллагуудын төлөвлөгөөний биелэлтийн явц, үр дүн,</li> <li>- Хяналт шалгалт, сар, улирал, хагас, бүтэн жилийн ажлын тайлан, дүн мэдээ,</li> <li>- Өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилт,</li> <li>- Газрын болон харьяа байгууллагуудын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгааны ажлын талаар,</li> <li>- Цаг үеийн болон бусад асуудлуудтай холбогдсон ажил гэх мэт,</li> </ul> <p>Хэрэгжилт 100%</p>
1.8.	Гадаад хэлний болон оффисын техник тоног төхөөрөмжийг ашиглахтай холбоотой мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	<p>Мэргэжилтэн Н.Өлзийжаргал албан хаагчдад орос, англи хэл, оффисын хэрэглээний програмуудын ашиглалт, түүнээс гарсан алдаа дутагдлыг цаг тухай бүрт нь засаж заавар зөвлөгөөг тогтмол өгч ажилласан.</p> <p>Хэрэгжилт 100%</p>
1.9.	Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр ажил үйлчилгээ эрхэлдэг үйл ажиллагаа явуулдаг иргэд арга зүйч мэргэжилтнүүдийн	<p>Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр 2017 онд 7 удаагийн сургалт зохион байгуулж 395 байгууллагын 985 иргэнийг хамруулж 569.900 төгрөг зарцуулсан.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Цэцэрлэгийн багш арга зүйчдэд зориулсан “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” сэдэвт сургалт семинар</li> <li>2. Ерөнхий боловсролын сургуулийн</li> </ol>

	мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах.	багш, арга зүйчдэд зориулсан “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” сэдэвт сургалт семинар 3. “Улаанбаатар марафон – Олон улсын гүйлт”-ийн шүүгчдийн сургалт 4. Олс таталтын сургагч багш бэлтгэх сургалт семинарыг зохион байгуулсан тухай 5. “Эрүүл ажлын байр таниас эхэлнэ” сэтгэл зүйн сургалт семинар 6. Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодын албан хаагчдад зориулсан “Хууль тогтоомж, эрх зүй”-н сургалт семинар 7. Бадминтоны сургагч багш бэлтгэх сургалтыг тус тус зохион байгуулсан.	Хэрэгжилт 100%
<b>Хоёр. Нийгмийн асуудлын талаар</b>			
2.1.	Албан хаагч болон тэдгээрийн гэр бүл үр хүүхэд төрүүлэх зэрэгт байгууллагын дотоод журамд заасны дагуу мөнгөн болон бодит урамшуулал олгох, хууль журмын дагуу чөлөө олгох.	Байгууллагын дотоод журмыг үндэслэн буцалтгүй тусламж 2 хүнд /Б/18, Б/19/, Түлээ нүүрсний тэтгэмж 1 хүнд /Б16/ олгосон.	Хэрэгжилт 100%
2.2.	Засгийн газраас хэрэгжүүлж буй орон сууц хөтөлбөрт байгууллагын ажилтнуудаас хамруулах, хөнгөлттэй зээлд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх.	Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрт 2017 онд квот олгогдоогүй болно.	Хэрэгжилт 100%
2.3.	Албан хаагчдад хоол унааны хөнгөлөлт үзүүлэх.	Байгууллагын албан хаагчдад зохих хууль журмын дагуу хоол унааны зардлыг шийдвэрлэн тогтмол олгож байна.	Хэрэгжилт 100%
2.4.	Ажилтнуудад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэв, олгох нэмэгдүүлэх, ур чадварын нэмэгдэл, мэргэшлийн зэрэг олгуулах арга хэмжээ хэрэгжүүлэх.	↓ 2016 оны үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг үндэслэн албан тушаалын зэрэг дэвийг нэмэгдүүлэх асуудлыг Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлөөр шийдвэрлэсний дагуу мэргэжилтэн Гаасүрэнгийн Бямбасайхан, Болдын Түвшинбаяр нарыг ТЗ-5 ангилалаар 18 хувиар нэмэгдүүлэн цалинг олгож байна. ↓ Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын шалгалтад орж тэнцсэн Алтангэрэлийн Болдмааг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн даргад, Сурмаажавын Саранцэцэгийг Спортын хөгжлийн хэлтсийн даргын албан тушаалд ТЗ-8-4, ТЗ-8-5 шатлалын дагуу цалинг	

		<p>тогтоон, зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг хуулийн дагуу олгож байна.</p> <p>Архив, бичиг хэргийн эрхлэгч М.Цогзолмаад Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшлийн “Тэргүүлэх” зэргийн болзол хангасан тул 15%-ийн нэмэгдэл олгож байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
2.5.	Ажилтнуудын гэр бүл хүүхдүүдэд баяр ёслолын үеэр баярын мэнд хүргэж, гарын бэлэг гардуулах.	<p>Албан хаагчдад болон тэдний гэр бүлд эх үрсийн баяр, шинэ жил, цагаан сарын баяруудад хүндэтгэл үзүүлэх, гэр бүлийн бэлэг гардуулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
2.6.	Байгууллагын ахмадуудад ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх.	<p>Сар шинийн баяр, Олон улсын ахмад настны эрхийг хамгаалах өдөр, Монголын ахмадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороонд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан иргэн Г.Нямдорж, Ж.Цэдэнсодном, С.Пүрэвдорж, Н.Долгор нарыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
2.7.	Байгууллагын ажилтнуудад тусламж тэтгэлэг үзүүлэх ажлыг шаардлагатай үед зохион байгуулах.	<p>Байгууллагын дотоод журмыг үндэслэн буцалтгүй тусламж 2 хүнд /Б/18, Б/19/, Түлээ нүүрсний тэтгэмж 1 хүнд /Б16/ олгосон.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
2.8.	Байгууллагын ажилтнуудын гэр бүлийнхнийг оролцуулсан “Гэр бүл” өдрийг зохион байгуулах.	<p>“Гэр бүл” уулзалт тэмцээнийг 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдөр 6 гэр бүлийг хамруулан зохион байгуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
<b>Гурав. Шагнал урамшууллын талаар</b>		
3.1.	Албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан шагнаж, урамшуулах.	<p>Даргын Б/17, Б/20 тоот тушаалаар албан хаагчдад үр дүнгийн мөнгөн урамшуулал олгов. Мөн 2017 оны төсвийн давсан орлогоос төрийн өндөр албан тушаалтан, шүүх, прокуророос бусад төрийн албан хаагчдад 300 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай” заалтын дагуу олгов.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>

3.2.	Түүхт ой, тэмдэглэлт баяр ёслолын өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа идэвх санаачлага гарган албан үүргээ тогтмол чанартай биелүүлж, ёс зүйн зөрчилгүй ажиллаж байгаа албан хаагчийг дээд байгууллагын шагналд тодорхойлох.	<p>✦ Нийслэлийн өдрийг тохиолдуулан дараах албан хаагчдыг шагналд тодорхойлж, шагнуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны жуух бичгээр мэргэжилтэн М.Цогзолмаа,</li> <li>- Биеийн тамирын тэргүүний ажилтан хүндэт тэмдэгээр мэргэжилтэн Э.Мөнх-Эрдэнэ,</li> <li>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт тэмдэг”-ээр мэргэжилтэн Г.Бямбасайхан, Н.Өлзийжаргал, Б.Түвшинбаяр</li> <li>- Нийслэлийн Тэргүүний ажилтан цол тэмдэгээр Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга А.Болдмаа;</li> <li>- Монголын Үндэсний олимпын хорооны “Алтан очир” одонгоор Спортын хөгжлийн хэлтсийн дарга С.Саранцэцэг,</li> <li>- Монголын Үндэсний олимпын хорооны Алтан медалиар мэргэжилтэн Б.Түвшинбаяр,</li> </ul> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
3.3.	Нийслэл дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагын ажилтнуудаас оны шилдэг ажилтныг шалгаруулж урамшуулах ажлыг зохион байгуулах.	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын даргын А/73 тоот тушаалын дагуу Нийслэлийн 2017 оны шилдэг багшаар Ц.Ганбаатар /Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй цогцолбор сургуулийн багш/, оны шилдэг тамирчнаар Г.Тэмүүжин /Чингэлтэй дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчин/, оны шилдэг арга зүйчээр Л.Ганзориг /БЗД-н 129 цэцэрлэгийн арга зүйч/ нар шалгарлаа.</li> <li>- 2017 оны Нийслэл, дүүргийн оны тэргүүний биеийн тамир, спортын хамтлагийг шалгаруулах ажлыг зохион байгуулж нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас 2017 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хүлээн аваад байна. Шалгарсан багийг “Цасны баяр” өвлийн наадмын үеэр шагнаж урамшуулна.</li> </ul> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
3.4.	Биеийн тамир, спортын салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан ахмад тамирчин дасгалжуулагч биеийн тамир, спортын зүтгэлтнүүдийг хэвлэл мэдээллээр сурталчилах,	Спортын Сүлд телевизтэй хамтран Тэшүүрийн шигшээ багийн зөвлөх багш, МУГТ Л.Цэнд, Уран сайхны гимнастикийн МУГТ Д.Хишгээ нарыг телевизийн ярилцлагад оролцуулж олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа.

	алдаршуулах ажлыг зохион байгуулах /Сүлд TV/.	Хэрэгжилт 100%
<b>Дөрөв. Эрүүл мэндийн талаар</b>		
4.1.	Ажилтнуудыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах.	Албан хаагчдыг 2017 оны 02 дугаар сарын 20-нд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт урьдчилсан үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан.  Хэрэгжилт 100%
4.2.	Ажилтнуудыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлж спорт зааланд тоглох, усан спорт, фитнес сургалтын төвд хөнгөлөлттэй үнээр хичээллүүлэх.	Байгууллагын 4 эмэгтэй албан хаагчийг "Golden gem" фитнес клубд 70%-ийн хөнгөлөлттэй үнээр хичээллэх боломжийг бүрдүүлж хамтран ажилласан.  Хэрэгжилт 100%
4.3.	Нийслэл дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагын ажилтнуудын дунд спортын уулзалт тэмцээн зохион байгуулах.	Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороодын албан хаагчдын дундах "Хамтдаа -2017" спортын тэмцээн 2017 оны 11 дүгээр сарын 22-нд Сонгинохайрхан дүүргийн спорт ордонд зохион байгуулагдаж Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо багийн дүнгээр 5 дугаар байрт шалгарсан. Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагдах "Шилжин явах цом"-ын төлөө тэмцээнийг 2017 оны 09 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Багануур дүүрэгт зохион байгууллаа. Энэхүү тэмцээнд нийт Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын 10 байгууллагын 90 ажилтан албан, хаагчид оролцсон.  Хэрэгжилт 100%
<b>Тав. Ажлын байрны ая тухтай байдлыг хангах талаар</b>		
5.1.	Албан хаагчид ажлаа хэвийн тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс бичиг хэрэг, техник хэрэгслийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж ажиллах.	Албан хаагчид ажлаа хэвийн тасралтгүй явуулах үүднээс бичиг хэрэг, компьютер техник тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.  Хэрэгжилт 100%
5.2.	Байгууллагын компьютер техник тоног төхөөрөмжийг сайжруулах, аюулгүй ажиллагааг хангах.	Нийслэлийн Мэдээлэл технологийн газартай "Программ хангамж худалдах, худалдан авах" гурвалсан гэрээ байгуулан 11 компьютерт вирусны программ суулгасан. Байгууллагын байршил өөрчлөгдсөнтэй

		<p>холбогдуулан Нийслэлийн Мэдээллийн технологийн газарт хүсэлт тавьж утасгүй интернетийн төхөөрөмж суулгуулан, дотоод сүлжээ тавиулсан. Мэдээллийн технологийн өдөр тутмын хэвийн, аюулгүй ажиллагааг хангахын тулд байгууллагын албан хэрэгцээнд ашигладаг 4 компьютерийн гэмтлийг компьютерийн засварын газраар хийлгэсэн. Байгууллагын өдөр тутмын баримт бичиг боловсруулах үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор HP LaserJet M1132 маркийн 3 үйлдэлтэй принтер болон HP LaserJet 1102 маркийн 1 үйлдэлтэй принтерийн 285A маркийн хорыг 2017 онд 20 удаа захиалан авч албан хэрэгцээнд ашигласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
5.3.	Ажлын өрөө тасалгаанд цэцэг тарьж цэцэгжүүлэх ажлыг зохион байгуулах	<p>Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулан Засаг захиргааны IV байранд шилжин орж өрөө тасалгааг бүрэн цэцэгжүүлж ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
5.4.	Ажилтнуудад зориулан цайны булан бий болгох, тохижуулах	<p>Албан хаагчдад зориулан цайны буланг засварлан пейж, ус шүүгч, хоолны шүүгээг байршуулж ая тухтай байдлыг ханган ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>

ХЯНАСАН:  
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА



Ж.ГАНБОЛД

ТАЙЛАН ГАРГАСАН:  
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН  
ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

А.БОЛДМАА